




## ИНФОГРАФИК /3 ДУГААР САР/

### 1.ИНФЛЯЦИ

Жилийн инфляци 2016 оны 03 дугаар сард улсын хэмжээнд 1.7 хувь, Улаанбаатар хотод 1,1 хувьтай байна.


Суурь инфляци 03 дугаар сарын байдлаар жилийн 3,1 хувь байна.




### 2.МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт 2016 оны 03 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 98,7 тэрбум төгрөгөөр буюу 1%-иар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 210 тэрбум төгрөгөөр буюу 2.1%-иар өсч 10113,7 тэрбум төгрөг байна.

Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төг/




Мөнгөний нийлүүлэлт /жилийн өсөлт/



### 3.ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН АЛБАН НӨӨЦ



Гадаад валютын улсын албан нөөц /тэрбум ам.доллар/



2016 оны 02 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 1,2 тэрбум ам.доллар болж өмнөх сараас 9,54%-иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 12,12%-иар буурчээ.



#### 4. ХАДГАЛАМЖ

Нийт хадгаламж 03 дугаар сарын байдлаар 7572,2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 2,74%-иар өсчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 5467,3 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 1,8%-иар буюу 96,9 тэрбум төгрөгөөр өссөн, өмнөх оны мөн үеийнхээс 279,7 тэрбум төгрөг буюу 5,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.




#### 5. ЗЭЭЛ

2016 оны 03 дугаар сарын эцэст нийт зээлийн өрийн үлдэгдэл 11827 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 199 тэрбум төгрөгөөр буюу 1,7 хувиар өссөн ба өмнөх оны мөн үеийнхээс 444 тэрбум төгрөгөөр буюу 3,6 хувиар буурсан байна.



Нийт зээлийн 8,18 хувийг чанаргүй зээл эзэлж байна.



## 6. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ



2016 оны 03 дугаар сарын эцэст гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 658,6 тэрбум төгрөг болж өмнөх сараас 3,1 тэрбум төгрөгөөр буюу 0,47%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 44,2 тэрбум төгрөгөөр буюу 6,2 %-иар буурчээ.

## 7. ГАДААД ДОТООД ЦЭВЭР АКТИВ

Гадаад цэвэр актив өмнөх сараас 229,9 тэрбум төгрөгөөр буюу 5,3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 1037,6 тэрбум төгрөгөөр буюу 34 хувиар буурч -4086 тэрбум төгрөг болов.



## 8. ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ, КГ



2015/3 сар	287,0 кг
2015/4 сар	536,7 кг
2015/5 сар	895,4 кг
2015/6 сар	1344,1 кг
2015/7 сар	1647,6 кг
2015/8 сар	1993,8 кг
2015/9 сар	2793,5 кг
2015/10 сар	2674,0 кг
2015/11 сар	1518,4 кг
2015/12 сар	694,8 кг
2016/01 сар	644,1 кг
2016/02 сар	538,5 кг
2016/03 сар	679,5 кг